

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ


Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 73 дугаар тэмдэглэлд:

"XXXIII.1. Төрийн болон төсвийн байгууллагуудад 2012-2013 оны шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхдээ төсвийн хөрөнгийг хэмнэх, үргүй зардлыг багасгах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав:

1.1. Шинэ жилийн баярыг жилийн ажлаа дүгнэж, хамт олныг хөдөлмөр, бүтээлээрээ тэргүүлж байгаа хүмүүсээ алдаршуулах, хүүхэд багачуудаа баярлуулж тэмдэглэн өнгөрүүлэх;

1.2. Төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баярыг тэмдэглэх, архи, согтууруулах ундаа, тансаг урамшуулал худалдан авах болон өндөр үнэтэй эд зүйлсээр сугалаат тоглоом явуулах, өндөр үнээр урлагийн тоглолт авахыг хориглох;

1.3. Хамтран ажилладаг байгууллагуудад төсвийн хөрөнгө, байгууллагын мөнгөөр шинэ жилийн мэндчилгээ хэвлүүлэн солилцох, бэлэг дурсгалын зүйл худалдан авч бэлэглэдэг явдлаас татгалзаж, цахим мэндчилгээ явуулдаг болох." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР